2019 07 17
4434

# ДУНДГОВЬ АЙМАГ
# САЙХАН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр Дугаар 04 Онги

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "д", Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож хавсралт ёсоор батлсугай.

2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан хэмжээний дагуу аж ахуй нэгж, албан байгууллага, айл өрхүүдэд дагаж мөрдүүлж, хураамжийг байгаль хамгаалах санд төвлөрүүлэн зарцуулж хэрэгжилтийг хагас бүтэн жилээр Хуралд тайлнагнаж байхыг сумын Засаг дарга (Б.Түвшинбаатар), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ц.Тунгалаг), бүрдүүлэлт болон зарцуулалтад байнгын хяналт тавьж байхыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (П.Эрдэнэбаатар) нарт тус тус даалгасугай.

3. Үйлчилгээний хураамжийн хэмжээг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2008 оны 57 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА П.ЭРДЭНЭБААТАР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралт

## Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ

| № | Хог хаягдлын нормативын ангилал | | Хэмжих нэгж | Нэгжээс авах хураамжийн хэмжээ/төгрөгөөр/ | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Зуны төлбөр /5-10 сар/ | Өвлийн төлбөр /11-4 сар/ |
| 1 | Айл өрх | Гэр хороолол | 1 өрх | 3500 | 5000 |
| | | Орон сууц,амины орон сууц /Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон/ | 1 өрх | 1500 | 2500 |
| 2 | | Малчин өрх /жилд/ | 1 өрх | 6000 | |
| 3 | Зочид буудал, амралтын газар, жуулчны бааз /Жилд/ | | 1 ор | 8000 | |
| 4 | Хүүхдийн цэцэрлэг, ясли | | 1 хүүхэд | 100 | |
| 5 | Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ | | 1 сурагч | 50 | |
| 6 | Албан байгууллага, /банк, ... | | 1 ажилтан | 500 | |
| 7 | Театр /соёлын төв/ | | 1 суудал | 40 | |
| 8 | Эрүүл мэндийн байгууллага | | 1 ор | 600 | |
| 9 | Уурын зуух | | 1 уурын зуух | 276980 | |
| 10 | Мал нядалгааны газар /олноор мал нядлаж байгаа иргэд/ | | 1 мал | 500 | |
| 11 | Худалдаа, үйлчилгээ | Эмийн сан | м2 | 200 | |
| 12 | | Худалдааны төв, Хүнсний дэлгүүр, зах, супер маркет | | 300 | |
| 13 | | ШТС | | 320 | |
| 14 | | Авто засвар, дугуй засвар | | 500 | |
| 15 | | Үсчин, салон, гоо сайхан, оёдол, халуун ус, | | 360 | |
| 16 | | Ресторан, бар, кафе, цайны газар | 1 Суудал | 1000 | |
| 17 | Үйлдвэр | | м2 | 300 | |
| 18 | Барилгын хог хаягдал | | м2 | 2000 | |
| 19 | Уул уурхайн хог хаягдал | | | 170000 | |
| 20 | Хайгуулийн үйл ажиллгаа явуулж байгаа ААН | | | 100000 | |
| 21 | Фермерийн аж ахуй /тэжээвэр амьтан/ | Гахай | 1 гахай | 1000 | |
| 22 | | Тахиа | 1 тахиа | 800 | |